

ТАНИЛЦУУЛГА

“Тайгад амьдардаг цаатан иргэнд тэтгэмж олгох журам”-ыг шинэчлэх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 42 дугаар зарлигийн 1.1 дэх хэсэгт “Цаатан иргэдийн амьдралын нөхцлийг сайжруулах зорилгоор тайгад амьдардаг 18 хүртэл насны цаатан хүүхдэд тухайн бүс нутагт тогтоосон амьжиргааны доод түвшингийн 50 хувьтай тэнцэх хэмжээний, насанд хүрсэн иргэнд амьжиргааны доод түвшингийн хэмжээгээр сар бүр мөнгөн тэтгэмж олгох” чиглэлээр арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газарт чиглэл үүрэг болгосны дагуу Монгол Улсын Засгийн газраас “Ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2013 оны 168 дугаар тогтоолыг баталсан.

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 168 дугаар тогтоолд тайгад амьдардаг цаатан иргэнд Хангайн бүс нутгийн хүн амын амьжиргааны доод түвшин, хүүхдэд түүний 50 хувьтай тэнцэх хэмжээгээр сар бүр мөнгөн тэтгэмжийг олгох арга хэмжээг 2013 оны 06 дугаар сараас 2018 оны 06 дугаар сар хүртэл хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд хуучнаар Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2013 оны А/72 дугаар тушаалаар “Тайгад амьдардаг цаатан иргэнд тэтгэмж олгох журам”-ыг баталсан.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 213 дугаар тогтоолоор цаатан иргэдэд тэтгэмж олгох арга хэмжээг үргэлжлүүлэн зохион байгуулах, хуучнаар Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2013 оны А/72 дугаар тушаалаар батлагдсан “Тайгад амьдардаг цаатан иргэнд тэтгэмж олгох журам”-ыг шинэчлэх үүргийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад өгсөн тул журмыг шинэчлэн боловсруулсан.

Журмын төсөлд тэтгэмжид хамрагдаж байгаа ахмад настныг тайгад амьдарч байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан гэж илүү тодорхой болгож зохицуулж байнгын асаргаа шаардлагатай иргэн болон түүнийг асарч байгаа гэр бүлийн гишүүнийг тэтгэмжид хамруулахаар нэмж зохицууллаа.

Түүнчлэн тэтгэмжид хамрагдах цаатан иргэний нэрсийн жагсаалтыг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор биш харин сумын Амьжиргааг дэмжих зөвлөлөөр хэлэлцүүлж, Засаг даргын захирамжаар баталгаажуулж байхаар төсөлд тусгалаа.

Цаатны ёс заншил, өв соёлыг хадгалах, хамгаалах, цаа бугыг мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг, тарилгад тогтмол хамруулах, цаатан иргэдийг арилжааны зорилгоор цаа бугыг өөр бүс нутагт худалдан борлуулж дасан зохицох чадварыг алдагдуулахгүй байх нь орон нутгийн байгууллагуудын үүрэг байхаар зохицууллаа.

Тэтгэмж авч байгаа цаатан иргэдийг идэвхижүүлэх, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор өрхийн үйлдвэрлэл эрхлэлт, амьжиргааг дэмжих чиглэлээрх зөвлөгөө, сургалтад заавал хамрагдах үүрэгтэй байхаар журмын төсөлд тусгасан.

Мөн тэтгэмж авч байгаа цаатан иргэдийн хариуцлагыг нэмэгдүүлэх үүднээс бага насны хүүхдээ товлолын дагуу заавал хийх дархлаажуулалтад хамруулах, сургуулийн насны хүүхдээ албан ба албан бус боловсролд хамруулах, цаатан иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулж байгаа үзлэг, шинжилгээнд тогтмол хамрагдаж байх зэргийг журмын төсөлд оруулсан.

**МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ**

2018 оны.....сарын.....өдөр

Дугаар.....

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 42 дугаар зарлигийн 1.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 213 дугаар тогтоолын 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Тайгад амьдардаг цаатан иргэнд тэтгэмж олгох журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтийг ханган ажиллаж тэтгэмж олгох арга хэмжээг хавсралтаар батлагдсан журмын дагуу зохион байгуулахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /Б.Нямдаваа/, Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар /Б.Эрдэнэхуяг/ нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү журмыг хэрэгжүүлэх ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Ундрал/-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Мөнхзул/-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Хүн амын хөгжил, нийгмийн хамгаалал /хуучин нэрээр/-ын сайдын 2013 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/72 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Энэ тушаалыг 2018 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

САЙД

С.ЧИНЗОРИГ

ТАЙГАД АМЬДАРДАГ ЦААТАН ИРГЭНД ТЭТГЭМЖ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Цаатан иргэдийн амьдралын нөхцлийг сайжруулах зорилгоор тайгад амьдардаг 18 хүртэлх насны цаатан хүүхдэд Хангайн бүс нутагт тогтоосон амьжиргааны доод түвшингийн 50 хувьтай тэнцэх хэмжээний, насанд хүрсэн иргэнд амьжиргааны доод түвшингийн хэмжээгээр сар бүр мөнгөн тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Тэтгэмж авах эрх, бүрдүүлэх баримт бичиг

2.1. Цаа буга маллаж байгаа дараах нөхцлийг хангасан Монгол Улсын цаатан иргэн тэтгэмж авах эрхтэй. Үүнд:

2.1.1.сүүлийн 12 сар ба түүнээс дээш хугацаагаар тайгад амьдарч цаа буга маллаж байгаа цаатан иргэн;

2.1.2.цаатан иргэнтэй гэр бүл болж тайгад цаа буга маллан амьдарч байгаа бусад угсааны иргэн;

2.1.3.тайгад амьдарч байгаа цаатан иргэний суурин газарт сургуульд суралцаж байгаа хүүхэд болон тухайн хүүхдийг асарч байгаа гэр бүлийн гишүүн;

2.1.4.тайгад цаа буга маллаж байгаа цаатан өрхийн Цагаан нуур сумын төвд амьдардаг өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, эмчилгээ сувилгаа шаардлагатай иргэн, байнгын асаргаа шаардлагатай иргэн болон түүнийг асарч байгаа гэр бүлийн гишүүн.

2.2. Энэхүү нөхцлийг хангасан цаатан иргэн Цагааннуур сумын нийгмийн ажилтанд дараах баримт бичгийг бүрдүүлж өгнө:

2.2.1.иргэний үнэмлэх, хуулбарын хамт;

2.2.2.хүүхдийн төрсний гэрчилгээ, хуулбарын хамт;

2.2.3.цээж зураг 1 хувь;

2.2.4. энэхүү журмын 2.1.1, 2.1.2-д заасан иргэний цаа буга тоолуулсан тухай сумын мал үржлийн тасгийн тодорхойлолт;

2.2.5.энэхүү журмын 2.1.2-т заасан иргэний гэрлэлтийн гэрчилгээ, хуулбарын хамт;

2.2.6.энэхүү журмын 2.1.3-т заасан хүүхэд сурч байгаа сургуулийн тодорхойлолт, хүүхдээ асарч байгаа иргэний хувьд сумын Засаг даргын тодорхойлолт;

2.2.7. энэхүү журмын 2.1.4-д заасан иргэн аймгийн эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын орон тооны бус салбар комиссын шийдвэр болон сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч их эмчийн тодорхойлолт.

Гурав.Тэтгэмжид хамрагдах хүсэлтийг хянан шийдвэрлэх

3.1.Энэхүү журмын 2.2-т заасан баримт бичгийг бүрдүүлэн өгсөн иргэдийн хүсэлтийг Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын багийн дарга, сумын нийгмийн ажилтан ажлын 5 хоногийн дотор судлан үзэж, нэрсийн жагсаалт гаргаж сумын Амьжиргааг дэмжих зөвлөлөөр хэлэлцүүлнэ.

3.2.Сумын нийгмийн ажилтан нь Амьжиргааг дэмжих зөвлөл хэлэлцэж шийдвэрлэсэн тэтгэмжид хамрагдах шаардлага хангасан иргэдийн нэрсийн жагсаалтыг гарган Нийгмийн халамжийн мэдээллийн нэгдсэн сан (WAIS)-д бүртгэж, сумын Засаг даргын захирамжаар баталгаажуулж аймгийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад хүргүүлнэ.

3.3.Аймгийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь энэхүү журмын 3.2-т заасан мэдээллийг нягтлан шалгаж, Нийгмийн халамжийн мэдээллийн нэгдсэн сан (WAIS)-д баталгаажуулна.

3.4. Аймгийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь тэтгэмж авах шалгуур хангасан иргэдийн нэрсийн жагсаалтыг гэрээ байгуулсан арилжааны банк, сумын нийгмийн ажилтанд сар бүрийн 10-ны дотор хүргүүлнэ.

3.5. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэхүү журмын 3.3-д заасан мэдээллийг үндэслэн тэтгэмжийн сар, улирлын төсвийн хуваарийг хийж, санхүүжилтийг аймгийн Нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад сар бүрийн 15-ны дотор, аймгийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь тэтгэмжийн санхүүжилтийг тухайн сарын 20-ны дотор гэрээт банкинд тус тус шилжүүлнэ.

3.6. Сумын нийгмийн ажилтан нь энэхүү журмын 3.4-д заасан өрхөд тэтгэмж авах эрх үүссэн тухай мэдэгдэж, хувийн хэрэг нээж, тэтгэмж авах банкны салбар болон бусад шаардлагатай мэдээллийг өгнө.

Дөрөв. Тэтгэмж олголт

4.1.Тэтгэмжийг сар бүрийн 20-ны өдрөөс хойш иргэн өөрийн биеэр гэрээт банкнаас очиж авна. 16 насанд хүрээгүй хүүхдийн тэтгэмжийг эх /эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч/-д олгоно.

4.2.Тэтгэмжийг өөрийн биеэр авах боломжгүй нөхцөлд Нотариатын тухай хуулийн хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу итгэмжлэгдсэн хүнээр авахуулж болно. Хэрэв суманд нотариатч ажиллаагүй бол сумын Засаг даргын Тамгын газрын дарга Нотариатын тухай хуулийн 10.2-т заасны дагуу итгэмжлэл олгоно.

4.3. Иргэн тэтгэмжээ өөрийн дансанд шилжүүлэх хүсэлтэй бол үйлчилгээ үзүүлж байгаа банкиндаа хандаж шийдвэрлүүлнэ.

4.4. Сумын нийгмийн ажилтан нь энэхүү журмын 5.1.4-т заасан мэдээллийг үндэслэн хүүхдэд төрсөн болон үрчилж авсан сараас нь тооцож тэтгэмжийг олгох, иргэн нас барсан тохиолдолд нас барсны дараа сараас нь тооцож тэтгэмжийг зогсоох арга хэмжээг авч иргэний хувийн хэрэгт тэмдэглэл хийнэ.

4.5. Тэтгэмж авч байсан иргэн тухайн сумаас өөр газарт сурч, ажиллахаар шилжсэн, хуурамч баримт бичиг бүрдүүлэн тэтгэмж авсан нь хяналт шалгалтаар тогтоогдсон тохиолдолд сумын нийгмийн ажилтан хувийн хэрэгт тэмдэглэл хийж тэтгэмжийг зогсооно.

4.6. Цаатан өрх “Мал, тэжээвэр амьтдын тооллого”-оор өөрийн эзэмшлийн цаа бугыг бусдын эзэмшилд хуурамчаар бүртгүүлсэн нь хяналт шалгалтаар тогтоогдсон тохиолдолд сумын нийгмийн ажилтан хувийн хэрэгт тэмдэглэл хийж тэтгэмжийг зогсооно.

4.7. Тэтгэмж авах эрх үүссэн иргэн тэтгэмжээ тухайн ондоо авч чадаагүйн улмаас санхүүгийн жил өнгөрсөн нөхцөлд тухайн иргэний тэтгэмжийг дараа онд нь нөхөн олгоно. Тэтгэвэр, тэтгэмж авагчийн өөрийн буруугаас 12 сараас дээш хугацаагаар тэтгэмжээ аваагүй нөхцөлд нөхөн олгохгүй.

Тав.Тэтгэмжид хамрагдах иргэний үүрэг

5.1.Тэтгэмжид хамрагдах иргэн дараах үүргийг хүлээнэ.

5.1.1. Цаа бугаа маллаж, тоо толгойг өсгөх;

5.1.2 Тэтгэмжид хамрагдсан иргэн бага насны хүүхдээ товлолын дагуу заавал хийх дархлаажуулалтад хамруулах;

5.1.3. Тэтгэмжид хамрагдсан иргэн сургуулийн насны хүүхдээ албан ба албан бус боловсролд хамруулах;

5.1.4. Тэтгэмж авч байгаа цаатан өрхөд шинээр хүүхэд төрсөн, үрчлэн авсан, өрхийн гишүүн нас барсан, шилжсэн зэрэг ам бүлийн тоонд орсон өөрчлөлтийг 14 хоногийн дотор сумын нийгмийн ажилтанд мэдэгдэх;

5.1.5.Энэхүү журмын 2.1.1, 2.1.2-д заасан иргэн Аймгийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сумын Засаг даргын Тамгын газраас тайгад амьдарч байгаа цаатан иргэдийн амьжиргаа, өрхийн үйлдвэрлэл эрхлэлтийг дэмжих чиглэлээр зохион байгуулсан зөвлөгөө, сургалтад заавал хамрагдах;

5.1.6.Сумын Эрүүл мэндийн төвөөс цаатан иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулж байгаа үзлэг, шинжилгээнд тогтмол хамрагдан үзлэгийн хуудсыг сумын нийгмийн ажилтанд өгч хувийн хэрэгтээ хавсаргах;

5.1.7. Цаатны ёс заншил, соёлын биет болон биет бус өвийг хадгалах, хамгаалах.

Зургаа. Удирдлага, зохион байгуулалт

6.1. Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь цаатан иргэнд тэтгэмж олгох арга хэмжээг зохион байгуулж Нийгмийн халамжийн мэдээллийн нэгдсэн сан (WAIS)-мэдээллийн нэгдсэн санг хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.

6.2. Аймгийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь өрхийн үйлдвэрлэл эрхэлдэг цаатан өрх болон энэхүү журмын 2.1.3, 2.1.4-т заасан хөдөлмөр эрхлэх сонирхолтой, хөдөлмөрийн насны иргэний чадвар, боломжид тулгуурлан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдэд хамруулах талаар бүх талын зөвлөгөө, дэмжлэг туслалцааг үзүүлнэ.

6.3. Аймгийн Нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь тэтгэмж олголтын сар, улирлын тайланг гаргаж, хэрэгжилтийн үр дүнг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдээлнэ.

6.4. Сумын Засаг дарга нь цаа бугын тоо толгойг өсгөн нэмэгдүүлэх, цаатны ёс заншил, өв соёлыг хадгалах, хамгаалахад анхаарч, цаа бугыг мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг, тарилгад тогтмол хамруулах, цаатан иргэдийг арилжааны зорилгоор цаа бугыг өөр бүс нутагт худалдан борлуулж дасан зохицох чадварыг алдагдуулахгүй байхад анхаарч ажиллана.

6.5. Сумын Засаг дарга нь цаатан иргэдийн өрхийн үйлдвэрлэлийг дэмжих, аялал жуулчлалын улиралд зориулж жуулчдад гар урлалын бүтээгдэхүүнийг худалдан борлуулах чиглэлээр дэмжлэг үзүүлж ажиллана.

Долоо. Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх

7.1. Тэтгэмжийг олгох үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймгийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сумын Засаг дарга эрх хэмжээний хүрээнд хяналт тавина.

7.2. Сумын нийгмийн ажилтан, Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн хамт жилд 2-оос доошгүй удаа тэтгэмжид хамрагдсан өрхийн аж байдалтай танилцаж, хяналт үнэлгээ хийж энэхүү журмын 5.1-д заасан үүргээ удаа дараалан биелүүлээгүй, тэтгэмж авах шаардлагагүй иргэн хамрагдсан зэрэг зөрчлийн улмаас тухайн иргэнийг тэтгэмжээс хасах саналыг аймгийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад гаргаж болно.

7.3. Аймгийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь сумын нийгмийн ажилтан, Амьжиргааг дэмжих зөвлөлийн тэтгэмж олголттой холбоотой үйл ажиллагаанд хяналт тавьж, аливаа зөрчил гаргуулахгүй байхад анхаарч ажиллана.

7.4. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь тэтгэмж олгох арга хэмжээний хэрэгжилт үр нөлөөг үнэлэх ажлыг зохион байгуулна.

Шаардлагатай тохиолдолд тэтгэмж, үйлчилгээний үр нөлөөг үнэлэх ажлыг хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.

Найм. Бусад

8.1. Энэхүү журмын 5.1.4-т заасан үүргээ биелүүлээгүй эсхүл хуурамч баримт бичиг бүрдүүлэн тэтгэмж авсан иргэний тэтгэмжийг зогсоож, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

8.2. Энэхүү журмын 7.3-д заасан хяналт шалгалтаар тэтгэмжид хамрагдах иргэнийг буруу тогтоосон, аливаа ашиг сонирхол, улс төрийн зорилгоор тэтгэмжид хамрагдах шаардлагагүй иргэнийг тэтгэмжид хамруулсан, хамрагдах шаардлагатай иргэний өргөдөл хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлээгүй зэрэг зөрчил гаргасан нийгмийн ажилтан, Амьжиргааг дэмжих зөвлөлд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

8.3. Энэхүү журмын 2.2.4-2.2.7-д заасан баримт бичгийг үндэслэлгүй буюу хуурамчаар үйлдсэн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэж хохирлыг нөхөн төлүүлнэ.

8.4. Илүү олгогдсон тэтгэмжийг нөхөн төлүүлэх талаар шүүх, хяналт шалгалтын байгууллага, эрх бүхий улсын байцаагчийн шийдвэр гарсан бол тухайн иргэний сарын тэтгэмжийн 50-иас хэтрэхгүй хувиар суутгал хийж хохирлыг барагдуулна.

8.5. Энэхүү журмын 8.4-д зааснаас бусад тохиолдолд тэтгэмжээс суутгал хийхийг хориглоно.

---oOo---